

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 7 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар А/1066

Улаанбаатар
хот

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТҮГЖРЭЛ, АЧААЛЛЫГ БУУРУУЛАХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.12 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.11 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.8 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5.10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, 2026-2027 оны хичээлийн жил, сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа эхлэхтэй холбогдон нийслэлийн авто замын хөдөлгөөний эрчим нэмэгдэхээс үүсэх замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг зохицуулах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд үүрэг болгосугай.

1.1.Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/1037 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох журам”-ын 2.2-т заасны дагуу автомашины улсын дугаарын сүүлчийн орон нь тэгш тоо (0, 2, 4, 6, 8) -оор төгссөн автомашиныг 2026 оны 08 дугаар сарын 16, 18, 20, 22, 24, 26, 28, 30, 09 дүгээр сарын 02, 04, 06, 08, 10, 12-ны өдрүүдэд, сүүлчийн орон нь сондгой тоо (1, 3, 5, 7, 9)-оор төгссөн автомашиныг 2026 оны 08 дугаар сарын 15, 17, 19, 21, 23, 25, 27, 29, 31, 09 дүгээр сарын 03, 05, 07, 09, 11-ний өдрүүдэд, 07:00-21:00 цагийн хооронд бүсчлэлгүйгээр тус тус замын хөдөлгөөнд оролцуулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Тээврийн цагдаагийн албаны Замын цагдаагийн газар (С.Галбадрах), “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ (Ч.Хувьзаяа)-т;

1.2.Энэ захирамжийн 1.1-д заасан арга хэмжээнд Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/1037 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох журам”-ын 2.3-т зааснаас гадна цахилгаан тэжээлийн тээврийн хэрэгсэл болон зохих зөвшөөрөл, тоноглол бүхий бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүний түгээлт, татан авалт, оршуулга, авто зам, хот тохижилт, шугам сүлжээний засвар, үйлчилгээ, дипломат байгууллага, гадаад улсын зочин, төлөөлөгчид үйлчлэх, нийтийн тээвэр, стандартын шаардлага хангасан такси үйлчилгээ, сургууль, цэцэрлэг, байгууллагын ажилчдыг тээвэрлэх үйл ажиллагаанд ашиглах болон таних тэмдэг бүхий хэвлэл мэдээллийн байгууллагын тээврийн хэрэгслийг энэхүү захирамжийн үйлчлэлээс чөлөөлөн, шаардлагатай бүртгэлд хамруулж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн цагдаагийн удирдах газар (О.Ганбат), Тээврийн цагдаагийн алба Замын цагдаагийн газар (С.Галбадрах)-т, «Замын хөдөлгөөний удирдлагын төв» ОНӨТҮГ (Ч.Хувьзаяа)-т;

1.3.Нийтийн тээврийн үйлчилгээний сүлжээ, чиглэлийг шинэчлэн тогтоож, хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг Нийтийн тээврийн бодлогын газар (Г.Билгүүн)-т;

1.4.Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэл түгээх, сурталчлан таниулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулан хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Замын хөгжлийн төсөл, хөтөлбөрийн зохицуулагч (Л.Хосбаяр), мэдээллийг олон нийтэд шуурхай, хүртээмжтэй хүргэж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга (Ч.Бат-Оргил)-д тус тус үүрэг болгосугай.

2.Энэ захирамжгарсантай холбогдуулан Цагдаагийн байгууллагаас ажиллах албан хаагчдын хоол, шатахууны нэмэлт зардлыг төсвийн холбогдох зардлаас гаргахыг нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Ү.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч (Б.Мөнхбат)-д даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

Б.ПҮРЭВДАГВА

НИЙСЭЛЭЙН ХАМГАЙН ТЭМЦЭГ
Бүтээгдэнт дугаар 1995
ХАМГАЙН ҮНЭН
Монгол улсын
Албан тэдгээрийн нэгж
«*Ulaanbaatar*»
(гарын үсэг) (гарын үсгийн тэмдэг)
20 оны дугаар арван

[illegible]


தமிழ்ச்சொல்/ எழுத்துக்கள் :

Երևանի քաղաքապետարանի Գործադիր Դիմացման Եւ
 Կապերի Դեպարտամենտի Կապերի Եւ Կապերի Դեպարտամենտի

॥ १००० ॥

॥ श्रीगणेशाय नमः ॥





БАГАНУУР ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 6 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 29

Улаанбаатар
хот

ТОГТООЛ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.4, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.5 дахь заалтыг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит XIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Дүүргийн нутаг дэвсгэрт мөрдөгдөх малын тоо толгойн албан татварын хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Жил бүрийн төсөвт малын тоо толгойн албан татварын орлого, зарлагыг төлөвлөн батлуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг дарга (С.Даваасүрэн)-д даалгасугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга (Г.Гансэлэм)-д даалгасугай.

4.Энэхүү тогтоолыг Хууль зүй дотоод хэргийн яам хянан баталгаажуулсан өдрөөс эхлэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 01 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

П.ТӨГӨЛДӨР

*Багануур дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит XIII
хуралдааны 29 дүгээр тогтоолын хавсралт*

МАЛЫН ТОО, ТОЛГОЙН ТАТВАР ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Төрөл	Хэмжих нэгж	Нэг бод (бог)-д ногдох хураамж (мян.төг)
1.	Адуу	Төгрөг (жилээр)	2000
2.	Тэмээ		1800
3.	Үхэр		1800
4.	Ямаа		500
5.	Хонь		300

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 7662 дугаарт бүртгэв

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 21

Эрдэнэбулган
сум

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дах хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 06 дугаар тогтоолоор баталсан «Хэрэглэгчийн эрчим хүчний тарифын саналыг хянах, шалгах журам», “Долоон бар” ХХК-ийн 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 02/40 дүгээр албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлөөс БАТЛАХ нь:

1.“Долоон бар” ХХК-ны дулаан түгээх сүлжээнд холбогдсон Өлзийт сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Архангай аймгийн Өлзийт сумын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч “Долоон бар” ХХК /Ч.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд орон тооны гишүүн /А.Алтанчимэг/-т даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн “Тариф батлах тухай” 14 дүгээр тогтоол, хавсралтыг тус тус 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

ДАРГА

А.АЛТАНЧИМЭГ

ГИШҮҮН
ГИШҮҮН

С.БАТСҮХ
А.БАТБОЛД

Архангай аймгийн Зохицуулах зөвлөлийн
2026 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн
21 дүгээр тогтоолын хавсралт

**“ДОЛООН БАР” ХХК-ИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД
ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ
ХҮЧНИЙ ТАРИФ**

1.Архангай аймгийн “Долоон бар” ХХК-ийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон Өлзийт сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт		Төг/м³	2,233
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ	49,221
		Тогтмол	Төг/м³	869
3	Орон сууцны халаалт (хүн амьдарч буй талбай хамаарна)		Төг/м²	1,200

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 22

Эрдэнэбулган
сум

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дах хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Хэрэглэгчийн эрчим хүчний тарифын саналыг хянах, шалгах журам”, “Долоон бар” ХХК-ийн 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 02/40 дүгээр албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлөөс БАТЛАХ нь:

1. “Долоон бар” ХХК-ны дулаан түгээх сүлжээнд холбогдсон Өгийнуур сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан тарифыг 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Архангай аймгийн Өгийнуур сумын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч “Долоон бар” ХХК /Ч.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд орон тооны гишүүн /А.Алтанчимэг/-т даалгасугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн «Тариф батлах тухай» 13 дугаар тогтоол, хавсралтыг тус тус 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

ДАРГА

А.АЛТАНЧИМЭГ

ГИШҮҮН
ГИШҮҮН

С.БАТСҮХ
А.БАТБОЛД

Архангай аймгийн Зохицуулах зөвлөлийн
2026 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн
22 дугаар тогтоолын хавсралт

**“ДОЛООН БАР” ХХК-ИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД
ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ
ХҮЧНИЙ ТАРИФ**

1.Архангай аймгийн “Долоон бар” ХХК-ийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон Өгийнуур сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт		Төг/м³	2,275
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ	43,320
		Тогтмол	Төг/м³	925
3	Орон сууцны халаалт (хүн амьдарч буй талбай хамаарна)		Төг/м²	1,200

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 23

Эрдэнэбулган
сум

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дах хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 06 дугаар тогтоолоор баталсан “Хэрэглэгчийн эрчим хүчний тарифын саналыг хянах, шалгах журам”, “Долоон бар” ХХК-ийн 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 02/40 дүгээр албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлөөс БАТЛАХ нь:

1.“Долоон бар” ХХК-ны дулаан түгээх сүлжээнд холбогдсон Цэнхэр сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Архангай аймгийн Цэнхэр сумын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч “Долоон бар” ХХК /Ч.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд орон тооны гишүүн /А.Алтанчимэг/-т даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн «Тариф батлах тухай» 15 дугаар тогтоол, хавсралтыг тус тус 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

ДАРГА

А.АЛТАНЧИМЭГ

ГИШҮҮН
ГИШҮҮН

С.БАТСҮХ
А.БАТБОЛД

Архангай аймгийн Зохицуулах зөвлөлийн
2026 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн
23 дугаар тогтоолын хавсралт

**“ДОЛООН БАР” ХХК-ИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД
ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ
ХҮЧНИЙ ТАРИФ**

1.Архангай аймгийн “Долоон бар” ХХК-ийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон Цэнхэр сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт		Төг/м³	2,368
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ	38,291
		Тогтмол	Төг/м³	1,007
3	Орон сууцны халаалт (хүн амьдарч буй талбай хамаарна)		Төг/м²	1,200

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 24

Эрдэнэбулган
сум

ТАРИФ БАТЛАХ ТУХАЙ

Эрчим хүчний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.3 дах хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 06 дугаар тогтоолоор баталсан «Хэрэглэгчийн эрчим хүчний тарифын саналыг хянах, шалгах журам», “Долоон бар” ХХК-ийн 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 02/40 дүгээр албан бичгээр ирүүлсэн тарифын саналыг тус тус үндэслэн Зохицуулах зөвлөлөөс БАТЛАХ нь:

1.“Долоон бар” ХХК-ны дулаан түгээх сүлжээнд холбогдсон Хашаат сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тарифыг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан тарифыг 2027 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Архангай аймгийн Хашаат сумын төвлөрсөн дулаан хангамжийн хүрээнд дулаан түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч “Долоон бар” ХХК /Ч.Жаргалсайхан/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн дарга бөгөөд орон тооны гишүүн /А.Алтанчимэг/-т даалгасугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн “Тариф батлах тухай” 02 дугаар тогтоол, хавсралтыг тус тус 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн хүчингүй болгосугай.

ДАРГА

А.АЛТАНЧИМЭГ

ГИШҮҮН
ГИШҮҮН

С.БАТСҮХ
А.БАТБОЛД

*Архангай аймгийн Зохицуулах зөвлөлийн
2026 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн
24 дүгээр тогтоолын хавсралт*

**“ДОЛООН БАР” ХХК-ИЙН ДУЛААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭНД
ХОЛБОГДСОН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ДУЛААНЫ ЭРЧИМ
ХҮЧНИЙ ТАРИФ**

1.Архангай аймгийн “Долоон бар” ХХК-ийн дулаан түгээх сүлжээнд холбогдсон Хашаат сумын хэрэглэгчдэд борлуулах дулааны эрчим хүчний тариф (НӨАТ-гүй)-ыг ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Хэрэглэгчийн ангилал		Хэмжих нэгж	Тариф (НӨАТ-гүй)
1	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын халаалт		Төг/м³	1,841
2	Үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагын хэмжүүрээр тооцох халаалт	Хувьсах	Төг/ГЖ	28,642
		Тогтмол	Төг/м³	737
3	Орон сууцны халаалт (хүн амьдарч буй талбай хамаарна)		Төг/м²	1,200

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 278

Улаанбаатар
хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2025 оны 71 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

*Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны
07 дугаар сарын 09-ний өдрийн 278 дугаар
тогтоолын хавсралт*

БАНК БУС САНХҮҮГИЙН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Банк бус санхүүгийн байгууллагын зээлийн үйл ажиллагаанд баримтлах үзүүлэлт, түүнд тавих хяналт болон дэвшилтэт технологи ашиглан цахим (цаашид “финтек” гэх)-аар зээлийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Банк бус санхүүгийн байгууллага (цаашид “ББСБ” гэх) нь энэхүү журам болон холбогдох бусад хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актыг дагаж мөрдөнө.

ХОЁР. ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу зээлийн үйл ажиллагааны ерөнхий нөхцөл, журамд хуульд зааснаас гадна дараах харилцааг зохицуулсан баримт бичгийг баталж, мөрдөнө:

2.1.1.зээл судлах, шийдвэрлэх, олгох, хянах үйл ажиллагаа;

2.1.2.бүтээгдэхүүний хүү, шимтгэл, хураамж, хугацаа;

2.1.3.эрсдэлийг удирдах, зээлийн эргэн төлөлтөд тавих хяналт, хариуцлага;

2.1.4.харилцагчийн нууцлал, аюулгүй байдлыг хангах;

2.1.5.Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн талаар баримтлах бодлого;

2.1.6.харилцагчийн гомдол, маргаан шийдвэрлэх.

2.2.Барьцаа хөрөнгийн үнэлгээтэй холбоотой зохицуулалтыг хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох журамд тусган үйл ажиллагаандаа мөрдөнө.

2.3.Зээлийн гэрээнд Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т зааснаас гадна зээлдэгчийн цахим шуудангийн хаягийг тусгана.

2.4.Зээл олгохдоо харилцагчийн дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ:

2.4.1.эрх зүйн бүрэн чадамжтай эсэх;

2.4.2.санхүүгийн эх үүсвэр;

2.4.3.гэрээгээр хүлээсэн үүрэг, бусад зээл, төлбөр;

2.4.4.зээл эргэн төлөх чадвар.

2.5.Финтек зээл олгох болон зээлийн мэдээлэлд өөрчлөлт орох

бүрд мэдээллийг бодит цагийн горимоор, бусад зээлийн хувьд тухай бүр зээлийн мэдээллийн санд нийлүүлнэ.

2.6.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор шаардсан мэдээллийг гаргаж өгөхөөс татгалзсан этгээдэд зээлийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзана.

2.7.Зээл олгохоос татгалзсан тохиолдолд үндэслэл бүхий тайлбарыг харилцагчид мэдэгдэнэ.

2.8.ББСБ-аас олгох хэрэглээний зээл нь дараах өр, орлогын болон зээл, үнэлгээний харьцааг хангасан байна:

2.8.1.хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнд тооцох өр, орлогын харьцаа 55 хувиас хэтрэхгүй;

2.8.2.суудлын автомашин барьцаалсан болон худалдан авах хэрэглээний зээлийн зээл, үнэлгээний харьцаа 60 хувиас хэтрэхгүй ба үнэлгээг тооцохдоо автомашин худалдах, худалдан авах гэрээний үнэ эсхүл зах зээлийн үнийг үндэслэнэ.

2.9.Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс баталсан “Тогтвортой хөгжлийн зорилтуудын санхүүжилтийн таксономи”-ийн ангилалд хамаарах ББСБ-аас олгох ногоон болон нийгмийн зээлд энэ журмын 2.8 дахь хэсэг хамаарахгүй.

2.10.Энэ журмын 2.8.1-т заасан харьцааг энэ журмын хавсралтаар баталсан “Банк бус санхүүгийн байгууллагаас олгох хэрэглээний зээлд өр, орлогын харьцааг тооцох аргачлал”-ын дагуу тооцно.

2.11.ББСБ-ын хувьцаа эзэмшигчид зээл олгох тохиолдолд бусад зээлдэгчтэй ижил нөхцөлөөр зээл олгоно.

2.12.Зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдал, зээл эргэн төлөх чадварт эрсдэл учирсан тохиолдолд зээлдэгчид зээлийн гэрээний нөхцөлийг өөрчлөх тухай саналыг тавьж болно.

2.13.Зээлийн үйл ажиллагааны талаарх сурталчилгаанд Зар сурталчилгааны тухай хуулийг дагаж мөрдөх ба зээлийн хүү болон зээлийн бүтээгдэхүүний ерөнхий нөхцөлүүдийг тусгана.

2.14.Зээлийн үйл ажиллагаатай холбоотой үйлчилгээний шимтгэл, хураамжийг өмнөх жилийн салбарын дунджаас өндөр тогтоосон тохиолдолд Хорооноос бууруулах саналыг албан бичгээр мэдэгдэнэ.

2.15.ББСБ энэ журмын 2.14-т заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор үйлчилгээний хураамж, шимтгэлийн хэмжээг бууруулсан талаарх шийдвэрийг буцаан мэдэгдэх ба буцаан мэдэгдээгүй тохиолдолд Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7-д заасны дагуу Хороо шийдвэрийг хүчингүй болгож, энэ тухай нийтэд мэдээлнэ.

2.16.Нийгмийн хариуцлагын хүрээнд олон нийтэд санхүүгийн боловсрол олгох арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

ГУРАВ. ФИНТЕК ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1.ББСБ нь дэвшилтэт технологийн шийдэл ашиглан финтек зээлийн үйлчилгээг зах зээлд гаргахаас ажлын 10 өдрийн өмнө Хороонд урьдчилан мэдэгдэнэ.

3.2.Финтек зээлийн үйлчилгээ гаргахад дараах үзүүлэлтийг хангана:

3.2.1.Мэдээллийн аюулгүй байдлын ISO/IEC 27001 стандарт, эсхүл үүнтэй дүйцэх стандартыг хангах;

3.2.2.хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 5,000,000,000 (таван тэрбум) төгрөгөөс доошгүй байх.

3.3.Финтек зээлийг олгохдоо дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1.зээл олгох бүрд мэдээллийн эзний зөвшөөрлөөр гарын хурууны хээнээс бусад биометрик мэдээллийг ашиглан харилцагчийг таньж баталгаажуулах;

3.3.2.харилцагчийн зээлийн эрхийг энэ журмын 2.8.1-т заасан харьцаанд үндэслэн автомат тооцоолол хийх тохиргоотой байх;

3.3.3.харилцагчид зээлийн шугамын эрх нээх тохиолдолд 3 сараас ихгүй хугацаанд өр, орлогын харьцааг дахин тооцож, зээлийн эрхийг шинэчилдэг байх.

3.4.Харилцагчийн зээлийн эрхийг тооцоолж финтек зээлийн гэрээ байгуулсан даруй зээлийн эрхийг зээлийн шугам хэлбэрээр энэхүү журмын 2.5-д заасны дагуу Зээлийн мэдээллийн санд мэдээлнэ.

3.5.Харилцагчийн зээлийн лавлагаанд сүүлийн 72 цагийн дотор 5-аас доошгүй банк, санхүүгийн байгууллага зээл судалсан тухай бүртгэгдсэн бол тухайн ББСБ нь зээл судлах хугацааг 24 цагаар хойшлуулж, зээлийн лавлагааг шинэчлэн авсны үндсэн дээр зээл олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.6.ББСБ нь үйл ажиллагааны зардлаа бууруулах зорилгоор гуравдагч этгээдийн мэдээллийн технологийн системд холбогдон тухайн программ хангамжид боловсруулагдсан мэдээллийг ашиглан зээл олгох тохиолдолд Хороонд энэ журмын 3.1-т заасны дагуу урьдчилан мэдэгдэнэ.

3.7.Энэ журмын 3.6-д заасан гуравдагч этгээд нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т заасан шаардлагыг хангасан байна.

3.8.ББСБ нь финтек зээлийн бүтээгдэхүүн гаргасантай холбоотойгоор Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6, 17.1.7-д заасан үүргийг биелүүлж ажиллах ба холбогдох дүгнэлт, зөвлөмж, шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайлан, мэдээллийг дараа оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

“Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-ын хавсралт

БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС ОЛГОХ ХЭРЭГЛЭЭНИЙ ЗЭЭЛД ӨР, ОРЛОГЫН ХАРЬЦААГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

НЭГ. НИЙТЛЭГ ЗҮЙЛ

1.1.Энэхүү аргачлалыг ББСБ-аас хэрэглээний зээлийг шинээр олгох, өмнө олгосон зээлийн нөхцөлийг өөрчлөхөд мөрдөнө.

1.2.“Хэрэглээний зээл”-д ББСБ-аас иргэнтэй харилцан тохиролцож, тодорхой хугацаанд эргэн төлөх нөхцөлтэйгөөр, иргэний өрхийн болон хувийн хэрэгцээнд зориулан олгосон зээл, санхүүгийн үйлчилгээг хамруулна.

Тайлбар: Хэрэглээний зээл нь иргэний цалин, бусад орлого, хөрөнгийг барьцаалсан, эсхүл үүргийн гүйцэтгэлийг хангах бусад аргаар баталгаажсан байж болно. Тухайлбал, финтек зээл, автомашины зээл, цахилгаан барааны зээл зэрэг эдгээртэй төстэй бусад гэрээ, хэлцлийг хамааруулна.

1.3.Энэхүү аргачлалд дараах төрлийн зээл хамаарахгүй.

1.3.1.итгэлцэл барьцаалсан зээл;

1.3.2.ипотекийн зээл;

1.3.3.үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээл;

1.3.4.иргэдийн жижиг, дунд бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зориулалттай зээл;

1.3.5.амьжиргааны доод түвшнээс бага дүнтэй зээл;

Тайлбар: Тухайн иргэний банк бус санхүүгийн байгууллагуудаас авсан энэ аргачлалын 1.3.5-д хамаарах олгосон зээлийн дүн нь амьжиргааны доод түвшнээс ихгүй байхыг ойлгоно.

1.3.6.сургалтын төлбөрийн зээл.

1.4.“Зээлийн нөхцөлийг өөрчлөх” гэдэгт зээлийн хугацааг өөрчлөх, нэмэлт зээл олгох, зээлийн хэмжээний эрхийг нэмэгдүүлэх, эргэн төлөлтийг хойшлуулах тохиолдлыг хамааруулна.

1.5.Аргачлалын 1.4-т жирэмсний болон амаржсаны, хүүхэд асрах чөлөөтэй, эмнэлгийн комиссоор хөдөлмөрийн чадвараа алдсан иргэдийн хувьд орлого буурсан саруудад үндэслэн зээлийн хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хугацааг сунгах тохиолдол хамаарахгүй.

ХОЁР. ОРЛОГЫГ ТОДОРХОЙЛОХ

2.1.Зээлдэгчийн орлогыг дараах байдлаар тодорхойлно:

2.1.1.цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлоготой иргэний хувьд нийгмийн даатгалын шимтгэлээр баталгаажсан орлого, эсхүл тухайн иргэний банкны тодорхойлолт, дансны хуулга, холбогдох гэрээ, хэлцэл,

данс тооцоо, бусад баримтаар нотлогдох гарт олгосон тогтмол мөнгөн орлого;

Тайлбар: Жирэмсний болон амаржсаны, хүүхэд асрах, эрүүл мэнд, сургалтын чөлөөтэй байсан иргэний хувьд ажилдаа эргэн орсон хугацаа 6 сар хүрэхгүй тохиолдолд чөлөө авахаас өмнөх 6 сарын орлогыг тооцооллолд ашиглаж болно.

2.1.2.мал өмчилдөг иргэний хувьд мал тооллогын хамгийн сүүлийн албан ёсны мэдээ буюу малын А дансны лавлагаанд тооцоолсон малын ашиг шимийн орлого, эсхүл тухайн малчны банкны тодорхойлолт, дансны хуулга, данс тооцоо, бусад холбогдох баримтаар нотлогдсон тогтмол орлого;

2.1.3.үйл ажиллагааны орлоготой иргэний хувьд татварын байгууллагаас баталгаажуулсан орлого, эсхүл Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй банкны тодорхойлолт, дансны хуулга, холбогдох гэрээ хэлцэл, данс тооцоо, бусад холбогдох баримтаар нотлогдсон тогтмол мөнгөн орлого;

Тайлбар: Энэ төрлийн орлогод Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8.1-т заасан үйл ажиллагааны орлого, 9.1.1-т заасан “хөрөнгө ашиглуулсан, түрээслүүлсний орлого”, 12.1.3-т заасан “бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого” буюу “ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй ил задгай худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа иргэд” болон “хувиараа зорчигч, эсхүл ачаа тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа иргэд”-ийн орлого зэрэг хамаарч болно.

2.2.Сарын дундаж орлогыг үндсэн зээлдэгч, хамтран зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгчийн энэ аргачлалын 2.1-т тусгагдсан орлогуудын сүүлийн 6 сарын дундаж орлогоор тооцно.

ГУРАВ. САРЫН ТӨЛБӨРИЙГ ТООЦОХ

3.1.Зээлийн сарын төлбөрийг тодорхойлохдоо үндсэн зээлдэгчийн эргэн төлөлтийн хуваарь дахь сарын нийт төлбөрийн дүн дээр хамтран зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгч нарын бусад бүх төрлийн зээлийн сарын төлбөрийг нэмж тооцоолно.

3.1.1.Кредит карт, овердрафт эрхтэй харилцах данс эзэмшдэг зээлдэгчийн хувьд банк, санхүүгийн байгууллагаас тогтоосон зээлийн эрхийн 10 хувиар, финтек зээлийн шугамын эрхтэй зээлдэгчийн хувьд банк бус санхүүгийн байгууллагаас тогтоосон зээлийн эрхийн дүнгээр зээлийн төлбөрт тооцно.

3.2.Үндсэн зээлдэгч, хамтран зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгч нарын бусад бүх төрлийн зээлийн сарын төлбөрүүдийн мэдээллийг зээл хүсэгчээс гаргуулан авч зээлийн сарын төлбөрийн тооцооллолд ашиглана.

ДӨРӨВ. ӨР, ОРЛОГЫН ХАРЬЦААГ ТООЦОХ

4.1.Зээлдэгчийн өр, орлогын харьцаа (цаашид “ӨОХ” гэх)-г дараах томьёоны дагуу тооцно:

$$\text{ӨОХ} = \frac{\sum_{i=1}^n P_i}{\text{СО}} * 100\% \leq M$$

M – Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон ӨОХ-ны дээд хязгаар

P_i – Аргачлалын 3.1 дэх хэсгийн дагуу тооцсон зээлийн сарын төлбөр

n – Зээлийн тоо

СО – Аргачлалын 2.2 дахь хэсгийн дагуу тооцсон сарын орлого

4.2.ББСБ нь иргэдийн хэрэглээний зээл тус бүрийн хувьд энэ аргачлалын дагуу зээлдэгчийн ӨОХ-г тооцно.

4.3.Зээлийн хугацааг гэрээнд тусгасан хугацаагаар тодорхойлно.

4.4.ББСБ нь зээлийн эрсдэлээс хамааруулан өөрийн эрсдэлийн удирдлагын бодлоготой уялдуулж зээлдэгчийн ӨОХ-г Хорооноос тогтоосон ӨОХ-ны дээд хязгаараас багаар тогтоож болно.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 282

Улаанбаатар
хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.5, 6.2.8, Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 211 дүгээр тогтоолын долоодугаар хавсралтыг энэ тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 211 дүгээр тогтоолын тавдугаар хавсралтаар баталсан “Зохицуулалтын үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх журам”-ын 3.9 дэх хэсэг, мөн тогтоолын долоодугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

*Санхүүгийн зохицуулах хорооны 2026 оны
07 дугаар сарын 09-ний өдрийн 282 дугаар
тогтоолын хавсралт*

*Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны
07 дугаар сарын 08-ны өдрийн 211 дүгээр
тогтоолын долоодугаар хавсралт*

**ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧЭЭС ТӨВЛӨРҮҮЛЭХ
ЗОХИЦУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛСНИЙ ХЭМЖЭЭ**

№	Зохицуулалтын үйлчилгээ	Үйлчилгээний хөлс	Хугацаа
1	Виртуал хөрөнгө, албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд арилжих; Нэг болон олон төрлийн виртуал хөрөнгийг хооронд арилжих; Виртуал хөрөнгийг шилжүүлэх	5,000,000 төгрөг	Жил бүр
2	Виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах	5,000,000 төгрөг	Жил бүр
3	Виртуал хөрөнгийг нийтэд санал болгох, худалдахтай холбоотой үйл ажиллагааг зохион байгуулах, санхүүгийн үйл ажиллагаанд оролцох болон үйлчилгээ үзүүлэх	10,000,000 төгрөг	Тухай бүр

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 7 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 335

Улаанбаатар
хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг Засгийн газрын 2026 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 25 дугаар хуралдааны тэмдэглэлээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1.Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 34 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний удирдах албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалын ангилалд адилтган авч үзэх албан тушаалын жагсаалт”-д дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай.

1.1.Төрийн захиргааны “Эрхэлсэн түшмэл”-ийн албан тушаалтай адилтгах “Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын нэр” хэсэгт “Шинжлэх ухааны академийн газрын дарга” гэж, Төрийн захиргааны “Ахлах түшмэл”-ийн албан тушаалтай адилтгах “Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын нэр” хэсэгт “Шинжлэх ухааны академийн хэлтсийн дарга” гэж тус тус нэмэх;

1.2. Төрийн захиргааны “ахлах түшмэл”-ийн албан тушаалтай адилтгах “Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын нэр” хэсэг дэх “Шинжлэх ухааны академийн орлогч дарга” гэснийг, Төрийн захиргааны “дэс түшмэл”-ийн албан тушаалтай адилтгах “Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын нэр” хэсэг дэх “Шинжлэх ухааны академийн хэлтсийн дарга” гэснийг тус тус хасах;

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба (В.Жавзан)-нд даалгасугай.

ДАРГА

Л.ЦЭДЭВСҮРЭН